

## ХОВД АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАЙНААС ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2021.10.21

Улаанбаатар хот

ИНЕГ-ын даргын баталсан 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн Орон нутгийн зарим нисэх буудлуудын үйл ажиллагаанд зайнаас дотоод аудит, хяналт шалгалт хийх 22/21 дугаартай удирдамжийн дагуу ИНЕГ-ын харьяа Ховд аймаг дахь нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ын аудитор А.Мөнх-Эрдэнэ, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг зайнаас хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Ховд аймаг дахь нисэх буудлын 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4.7.-д заасны дагуу ИНУТ нь тус нисэх буудлын 2021 оны эхний хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хянаж хагас жилээр үнэлж дүгнэлт, зөвлөмж хүргүүлээгүй байна.

Ховд нисэх буудлын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралтад заасны дагуу боловсруулаагүй шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хооронд нь уялдуулаагүй, хугацааг хэт ерөнхий төлөвлөсөн.

Ховд аймаг дахь нисэх буудлын даргын 2020 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд гаргасан тушаал шийдвэрүүдийг шалгахад тушаалын үндэслэл хэсэгт хууль, дүрэм журмын заалтыг буруу бичих, “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг зөрчих, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд байна.

Монгол Улсын Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ыг мөрдөж ажиллаагүй байна.

Ховд нисэх буудал 2020 онд удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, албан даалгаврын биелэлтийг бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн боловч бүртгэл хяналтын карт хөтлөөгүй, биелэлтийг гаргаагүй бөгөөд 2021 онд удирдах дээд байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн хэрэгжилт, албан даалгаврын биелэлтийг дутуу гаргасан байна.

Засгийн Газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор баталсан Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журмын дагуу гэрээ байгуулахдаа дугаарлаагүй, гэрээний бүртгэл хяналтыг хөтлөөгүй, гэрээг дүгнээгүй байна.

Цаг бүртгэлийн цахим бүртгэлийг ямар нэг шийдвэргүйгээр ашиглахгүй байгаа нь ИНЕГ-ын Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчиж байна. Цагийн бүртгэл хөтлөлт хангалтгүйгээс ажлын цагийн товчоо, бүртгэлийг үнэн зөв гаргахгүй байх, ажилчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавих боломжгүй болох нөхцөл бүрдсэн байна.

Нислэгийн удирдагчийн мэргэжлийн зэргийн хүчинтэй хугацаа дууссан байхад нэмэгдэл хөлс илүү олгосон.

ИНЕГ-ын даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/901 дүгээр тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3.2.-т заасан Бараа материалын бүртгэлийн горимыг хангалттай хэрэгжүүлээгүй, үндсэн хөрөнгийг буруу бүртгэсэн, санхүүгийн програмд бараа материалын бүлгийг алдаатай сонгосон.

Ховд аймаг дахь нисэх буудлын 2021 оны 01 дүгээр сараас 10 дугаар сар хүртэл хугацааны санхүүгийн баримтыг шалгахад холбогдох хууль, журамд заасны дагуу анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллаж байгаа боловч дахин давтагдашгүй баримт (и-баримтгүй) 3 гүйлгээ илэрснийг цаашид анхаарах шаардлагатай байна.

Ховд аймаг дахь нисэх буудал нь 2020 онд шатахуун худалдан авахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Худалдан авах ажиллагааны журмыг буруу сонгосон, Тендерийн урилгыг нийтэд зарлан мэдээлэхдээ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу цахимаар явуулаагүй, мөн хуулийн 49 дүгээр зүйлд заасны дагуу хавтаст хэрэг үүсгэж архивлаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан журмыг буруу сонгож 2020 онд нүүрс, 2021 онд нүүрс, барилгын засварыг тендер шалгаруулалт явуулахаар төлөвлөсөн боловч хэрэгжүүлээгүй шууд худалдан авалт хийсэн.

Ховд нисэх буудлын Аюулгүй ажиллагаа, дотоод хяналтын баг 2021 онд хийх ажлын төлөвлөгөөндөө ХАБЭА-г хангах талаар 9 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар шалгаж үзэхэд 89 хувийн гүйцэтгэлтэй явж байна. Гүйцэтгэл хэдий сайн байгаа боловч хийсэн ажлаа тайлагнах тал дээр хангалтгүй байна.

Дотоод аудитын шалгах өдрийн байдлаар тус нисэх буудлын орон тооны бус дотоод хяналтын баг нь 9 нэгжид 18 үзлэг шалгалт явуулахаар төлөвлөснөөс 2 нэгжид 1 удаагийн шалгалтыг хийсэн буюу дотоод хяналтын багийн төлөвлөгөө хангалтгүй байдалтай байна.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ байгуулах, дүгнэх журмын 2.1.-д ....Төрийн өмчит хуулийн этгээдтэй төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 1 (нэг) хүртэл жилийн хугацаагаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна... гэж заасныг зөрчиж, сунгалт хийгээгүй байна.

Ховд аймаг дахь нисэх буудлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад 2020 онд хуулийн хугацаа хоцроодог, дутуу мэдээлдэг, алдаатай мэдээлсэн зэрэг зөрчлүүд гарч байсан боловч 2021 оноос засарсан байна.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг засаж, залруулах талаар тус нисэх буудалд 19 зөвлөмж өгсөн болно.

## ДОТООД АУДИТЫН АЛБА